

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 18, 28 ДУГААР ТОЙРОГТ ЯВАГДАХ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХОО ИЛЭРХИЙЛЭХЭД
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

2021.7.21

/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиас/

26 дугаар зүйл. Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх

26.1. Нам, эвсэл Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, сонгуульд оролцох тухай хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

/Коронавируст халдвар /Covid-19/ цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа зөвлөмж, арга хэмжээний хүрээнд нам, эвслийн баримт бичгийг хүлээн авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна.

1. Нам, эвслийн баримт бичгийг 2021 оны 08 дугаар сарын 09, 10-ны өдрүүдийн 10:00, 12:00, 14:00, 16:00 цагуудад хүлээн авна.

2. Нам, эвслийн баримт бичгийг хүлээлгэн өгөх төлөөлөл ирэхдээ амны хаалт /маск/, нэг удаагийн бээлийтэй байна.

3. Нам, эвслийн төлөөлөл Төрийн тусгай хамгаалалтын ажилтанд хувийн бичиг баримтаа шалгуулж, гараа ариутгасны дараа холбогдох баримт бичгээ ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.

4. Баримт бичгийг хүлээн авах ажиллагааг хуваарийн дагуу зохион байгуулах тул баримт бичгээ хүлээлгэн өгөх өдөр, цагийн талаарх мэдээллийг 8 дугаар сарын 5-ны өдрөөс өмнө тус Хорооны gesc@gec.gov.mn цахим хаягаар урьдчилан мэдэгдэнэ.

5. Баримт бичгийг хүлээлгэн өгөхдөө урьдчилсан мэдэгдсэн цагаа баримтлан, хоёроос илүүгүй хүний төлөөлөл ирэхийг анхаарна уу./

26.2. Сонгуульд оролцох хүсэлтэд нам, эвслийн дарга гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ даран баталгаажуулсан байна. Эвслийн тухайд эвсэлд нэгдэн орсон бүх намууд тамга /тэмдэг/ даран баталгаажуулна.

26.3. Нам сонгуульд оролцох хүсэлтдээ дараах баримт бичгийг хавсаргана:

26.3.1. сонгуульд оролцох тухай намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын шийдвэр;

26.3.2. намын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

26.3.3. намын улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн Улсын дээд шүүхээр баталгаажуулсан хуулбар;

26.3.4.сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүний эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт;

26.3.5.энэ хуульд нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх намын дотоод журам;

26.3.6.ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд уг намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;

26.3.7.намын сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл;

26.3.8.намыг төлөөлж Сонгуулийн ерөнхий хороотой харилцах гурван хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг.

26.4.Эвсэл сонгуульд оролцох хүсэлтдээ дараах баримт бичгийг хавсаргана:

26.4.1.сонгуульд оролцох тухай эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэр;

26.4.2.эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

26.4.3.эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн Улсын дээд шүүхээр баталгаажуулсан хуулбар;

26.4.4.эвслийг төлөөлөх байгууллагаар батлагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүний эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт;

26.4.5.энэ хуульд нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх эвслийн дотоод журам;

26.4.6.ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд уг намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;

26.4.7.эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл;

26.4.8.эвслийг төлөөлж Сонгуулийн ерөнхий хороотой харилцах гурван хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

26.4.9.эвслийн гэрээний хуулбар;

26.4.10.эвсэл байгуулах тухай нам тус бүрийн шийдвэр.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО